



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ЗӨВЛӨМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,  
Нийслэлийн засаг захиргааны III байр  
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09  
<http://www.ub.inspection.gov.mn>  
E-mail: [ub\\_info@inspection.gov.mn](mailto:ub_info@inspection.gov.mn)

2017.02.22 № 02-01-001/24  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Манай газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Геодези, зураг зүйн тусгай зөвшөөрөл эзэмшигч танай компанийн үйл ажиллагаанд хяналт шалгалт” хийгдэнэ.

Эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор МХЕГ-аас батлагдсан 2.18 дугаартай “Геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийг шалгах хяналтын хуудас”-аар шалган, үнэлгээг тодорхойлж, хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, үнэлгээ дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зохих арга хэмжээ авахад оршино.

Өмнөх онуудад хийгдсэн хяналт шалгалт, зохион байгуулагдсан сургалт, хэлэлцүүлэг, зөвлөн туслах үйлчилгээнээс шалгалтад хамрагдах аж ахуйн нэгжүүдэд “Геодези, зураг зүйн тухай” хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартуудыг үйлдвэрлэл, ажил үйлчилгээндээ мөрдөж, хэрэглэж хэвшүүлэх талаар урьдчилан сэргийлэх зөвлөмжийг гарган хүргүүлж байна. Үүнд:

1. Засгийн газрын 25 дугаар тогтоолын дагуу геодезийн хэмжлийг солбицол, өндрийн улсын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх;
2. Геодезийн хэмжлийн багажиндаа баталгаажуулалт хийлгэх;
3. Монгол Улсын “Геодези, зураг зүйн тухай” хуульд заасны дагуу шинээр геодезийн байнгын цэг тэмдэгтүүдийг байгуулсан бол төрийн хамгаалалтад хүлээлгэн өгч байх;
4. Ашиглагдаж байгаа зураг, тоон мэдээллийг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авч, архив үүсгэн хадгалах;
5. Зохих хууль тогтоомжид заасан журмыг зөрчин байгууллага, аж ахуйн нэгжийн хийсэн зураг зүйн бүтээлийг хуулбарлаж, олшруулж, хэвлэж байгаа зөрчлийг зогсоох;
6. Инженерийн шугам сүлжээний газар дээрх ба доорх зураглалын ажилд инженерийн шугам сүлжээний зураглалын ажил /БД11-105-06/ норм дүрмийг баримтлан ажиллах;

001120503179

7. "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр кадастрын зураг хийхдээ Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалыг баримталж ажиллах;

8. Геодези, зураг зүйн мэргэжлийн аж ахуйн нэгжүүд нь Өмч, газрын харилцааны албанаас нэгж талбарын эргэлтийн цэгүүдийг газарт бэхлүүлэх мэдэгдэл өгөөгүй байхад газрын хэмжээ, заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, солбицолжуулах ажлыг хийхгүй байх;

9. Мэргэжлийн хяналтын байгууллага болон геодези, зураг зүйн мэргэжлийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудын оролцоотой хамтран чанаргүй геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээг таслан зогсоох, харилцан мэдээлэл солилцох;

10. Геодези, зураг зүйн мэргэжлийн аж ахуйн нэгжүүд нь геодези, зураг зүйн чиглэлийн их, дээд сургууль, мэргэжлийн сургалтын төвүүд, Фотограмметр, геодези, зураг зүйн холбоо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах;

11. Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн боловсруулан баталж хэрэгжүүлэх зэрэг зөвлөмжүүдийг ажил үйлчилгээ, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг зөвлөж байна.

Дээрх зөвлөмжид тусгагдсан заалтуудыг мөрдөж ажиллаагүй тохиолдолд "Захиргааны хариуцлагын тухай" хуулийн 38<sup>2</sup> дугаар зүйл, 49<sup>1</sup> дүгээр зүйл, "Геодези, зураг зүйн тухай" хуулийн 14 дүгээр зүйл, "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн 16 дугаар зүйлийн дагуу тус тус хариуцлага тооцох болно.

ДАРГА БӨГӨӨД УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ



Д.ЭРДЭНЭЧУЛУУН

ТАНИЛЦСАН:  
ДЭД ДАРГА БӨГӨӨД УЛСЫН  
АХЛАХ БАЙЦААГЧ



С.ДАВААСҮРЭН

ХЯНАСАН:  
БОГУУХХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ



Д.БАТ-ӨЛЗИЙ

БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР,  
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН  
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ



С.БОЛОРЦЭЦЭГ